



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/173/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2025 он	Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: Ари файнэнс аудит ХХК-ийн Захирал: Д.Ариунаа Утас: 99088151 Цахим хаяг: arifin.audit@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
4. Аудитын тайлан	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
БЕГ	Боловсролын ерөнхий газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН СҮХБААТАР
СУМЫН 4 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.БАЯРЖАРГАЛ ТАНАА

2025.02.25 № 00А-2025/173/НА-СНА-7113
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлын онцолсон хэсэг

Тус цэцэрлэг нь БШУЯ, БЕГ, аймгийн Боловсролын газраас 55,296.8 мянган төгрөгийн үнэ бүхий зөөврийн компьютер, зурагт, тавилга эд хогшил, Сүхбаатар сумын ОНХС-аас 16,000.0 мянган төгрөгийн хяналтын камер зэрэг үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээж авсан байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус цэцэрлэгийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 7 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

432502263

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 4 зорилтын хүрээнд 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 100.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	199,660,127.22	251,871,119.59
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	112,598,514.56	121,989,656.99
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	112,598,514.56	121,989,656.99
3121	Төгрөг	112,598,514.56	121,989,656.99
31211	Төрийн сангийн харилцах	112,598,514.56	121,989,656.99
35	БАРАА МАТЕРИАЛ	87,061,612.66	129,881,462.60
354	Хангамжийн материал	87,061,612.66	129,881,462.60
35410	Бичиг хэргийн материал	364,000.00	2,989,640.00
35420	Аж ахуйн материал	85,896,112.66	125,410,552.60
35460	Хүнсний материал	-	679,770.00
35470	Бусад хангамжийн материал	801,500.00	801,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,107,883,732.69	1,154,242,810.82
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,107,883,732.69	1,154,242,810.82
392	Биет хөрөнгө	1,056,871,732.69	1,103,230,810.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,234,606,149.00	1,234,606,149.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(289,457,327.86)	(311,928,631.18)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	112,476,225.19	153,697,866.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(88,168,989.24)	(61,553,368.02)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	82,174,944.55	82,591,173.16
39208	Хуримтлагдсан элэгдэл	(63,386,933.59)	(53,196,406.76)
39209	Зам, гүүрийн байгууламж	882,240.00	882,240.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(367,600.20)	(422,740.23)
39214	Бусад үндсэн хөрөнгө	67,096,550.00	67,096,550.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,370,396.16)	(10,928,892.15)
39217	Ном	2,386,871.00	2,386,871.00
393	Биет бус хөрөнгө	51,012,000.00	51,012,000.00
39301	Програм хангамж	2,021,100.00	2,021,100.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,021,100.00)	(2,021,100.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	51,012,000.00	51,012,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,307,543,859.91	1,406,113,930.41
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	369,800.00	222,600.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	369,800.00	222,600.00
413	Өглөг	369,800.00	222,600.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	341,800.00	222,600.00
4136	Бусад өглөг	28,000.00	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	28,000.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,307,174,059.91	1,405,891,330.41
51	Засгийн газрын хувь оролцоо	318,281,669.42	318,281,669.42
512	Хуримтлагдсан үр дүн	695,606,520.22	794,323,790.72
51210	Өмнөх үеийн үр дүн	581,498,413.68	695,606,520.22
51220	Тайлант үеийн үр дүн	114,108,106.54	98,717,270.50

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	293,285,870.27	293,285,870.27
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,307,543,859.91	1,406,113,930.41

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл <i>/төгрөгөөр/</i>
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,074,233,142.06	1,310,102,270.94
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	73,298,642.72	106,591,152.94
120	Нийтлэг татварын бус орлого	73,298,642.72	106,591,152.94
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	60,607,100.00	80,805,173.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	12,691,542.72	25,785,979.94
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,000,934,499.34	1,203,511,118.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	893,821,900.00	1,063,903,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	893,821,900.00	1,063,903,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	3,645,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	3,645,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	107,112,599.34	135,962,618.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	107,112,599.34	135,962,618.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	960,125,035.52	1,211,385,000.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	960,125,035.52	1,211,385,000.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	945,414,816.52	1,211,385,000.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	554,620,841.00	780,990,950.25
210101	Үндсэн цалин	390,165,881.42	537,045,823.64
210102	Нэмэгдэл	142,221,704.39	205,536,377.31
210104	Урамшуулал	22,233,255.19	38,408,749.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,069,879.23	95,975,583.32
210201	Тэтгэврийн даатгал	47,554,007.98	66,406,312.58
210202	Тэтгэмжийн даатгал	5,566,406.40	7,906,673.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,428,905.15	4,183,631.80
210204	Ажилгүйдлийн даатгал	1,047,341.97	3,495,793.26
210205	Эрүүл мэндийн даатгал	10,473,217.73	13,983,171.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	97,112,599.34	116,963,203.00
210301	Гэрэл, цахилгаан	7,808,549.81	7,854,210.00
210302	Түлш, халаалт	79,792,877.06	95,806,803.00
210303	Цэвэр, бохир ус	9,511,172.47	13,302,190.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,243,896.88	0.00
210408	Бараа материал акталсны зардал	11,243,896.88	0.00
2105	Нормативт зардал	114,779,130.00	117,290,260.00
210502	Хоол, хүнс	114,779,130.00	117,290,260.00

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,900,000.00	19,268,015.00
210604	Урсгал засвар	9,900,000.00	19,268,015.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,410,873.92	1,798,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,410,873.92	1,798,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	87,277,596.15	79,098,488.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,019,650.00	34,646,250.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,461,500.00	1,919,604.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	66,796,446.15	42,532,634.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,710,219.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,710,219.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,710,219.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	114,108,106.54	98,717,270.50
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	114,108,106.54	98,717,270.50

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,000,934,499.34	1,203,511,118.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,000,934,499.34	1,203,511,118.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	893,821,900.00	1,063,903,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	893,821,900.00	1,063,903,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	3,645,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	3,645,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	107,112,599.34	135,962,618.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	107,112,599.34	135,962,618.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	879,967,522.49	1,186,033,435.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	879,967,522.49	1,186,033,435.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	865,257,303.49	1,166,687,135.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	554,620,841.00	780,990,950.25
210101	Үндсэн цалин	390,165,881.42	537,647,518.29
210102	Нэмэгдэл	142,221,704.39	204,934,682.66
210104	Урамшуулал	22,233,255.19	38,408,749.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,069,879.23	95,975,583.32
210201	Тэтгэврийн даатгал	47,554,007.98	66,089,098.74
210202	Тэтгэмжийн даатгал	5,566,406.40	7,829,542.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,428,905.15	3,919,664.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,047,341.97	3,809,314.84
210205	Эрүүл мэндийн даатгал	10,473,217.73	14,327,963.43

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	97,112,599.34	116,963,203.00
210301	Гэрэл, цахилгаан	7,808,549.81	7,854,210.00
210302	Түлш, халаалт	79,792,877.06	96,806,803.00
210303	Цэвэр, бохир ус	9,511,172.47	12,302,190.00
2105	Нормативт зардал	113,598,460.00	118,089,230.00
210502	Хоол, хүнс	113,598,460.00	118,089,230.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	18,999,415.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	18,999,415.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,340,110.00	1,468,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,340,110.00	1,468,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,515,413.92	34,200,254.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,989,113.92	24,438,560.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,526,300.00	9,761,694.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,710,219.00	19,346,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,710,219.00	19,346,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,710,219.00	19,346,300.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	120,966,976.85	17,477,682.43
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,604,000.00	8,086,540.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,604,000.00	8,086,540.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,604,000.00	8,086,540.00
222001	Тоног төхөөрөмж	9,604,000.00	2,780,000.00
223001	Бусад хөрөнгө	0.00	5,306,540.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(9,604,000.00)	(8,086,540.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	111,362,976.85	9,391,142.43
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		112,598,514.56
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	112,598,514.56	121,989,656.99

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/Төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахиан үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	318,281,669.42	293,285,870.27	581,498,413.68	1,193,065,953.37
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	318,281,669.42	293,285,870.27	581,498,413.68	1,193,065,953.37
C07	Тайлант үеийн үр дүн			114,108,106.54	114,108,106.40

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	318,281,669.42	293,285,870.27	695,606,520.22	1,307,174,059.91
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	318,281,669.42	293,285,870.27	695,606,520.22	1,307,174,059.91
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	318,281,669.42	293,285,870.27	695,606,520.22	1,307,174,059.91
D08	Тайлант үеийн үр дүн			98,717,270.50	98,717,270.50
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	318,281,669.42	293,285,870.27	794,323,790.72	1,405,891,330.41

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,312,555,200.00	1,194,119,975.57	118,435,224.43	91.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,312,555,200.00	1,194,119,975.57	118,435,224.43	91.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,293,208,900.00	1,174,773,675.57	118,435,224.43	90.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	878,032,600.00	780,990,950.25	97,041,649.75	88.9
210101	Үндсэн цалин	615,312,900.00	537,647,518.29	77,665,381.71	87.4
210102	Нэмэгдэл	231,517,400.00	204,934,682.66	26,582,717.34	88.5
210104	Урамшуулал	31,202,300.00	38,408,749.30	(7,206,449.30)	123.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,660,600.00	95,975,583.32	6,685,016.68	93.5
210201	Тэтгэврийн даатгал	69,810,900.00	66,089,098.74	3,721,801.26	94.7
210202	Тэтгэмжийн даатгал	8,211,100.00	7,829,542.31	381,557.69	95.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,106,400.00	3,919,664.00	186,736.00	95.5
210204	Ажилгүйдлийн даатгал	4,106,400.00	3,809,314.84	297,085.16	92.8
210205	Эрүүл мэндийн даатгал	16,425,800.00	14,327,963.43	2,097,836.57	87.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	116,963,300.00	116,963,203.00	97.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	7,870,400.00	7,854,210.00	16,190.00	99.8
210302	Түлш, халаалт	95,806,900.00	96,806,803.00	(999,903.00)	101.0
210303	Цэвэр, бохир ус	13,286,000.00	12,302,190.00	983,810.00	92.6
2105	Нормативт зардал	126,828,100.00	118,089,230.00	8,738,870.00	93.1
210502	Хоол, хүнс	126,828,100.00	118,089,230.00	8,738,870.00	93.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,000,000.00	18,999,415.00	585.00	100.0
210604	Урсгал засвар	19,000,000.00	18,999,415.00	585.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,066,300.00	1,468,500.00	1,597,800.00	47.9

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,066,300.00	1,468,500.00	1,597,800.00	47.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,658,000.00	42,286,794.00	4,371,206.00	90.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,894,800.00	32,525,100.00	4,369,700.00	88.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,763,200.00	9,761,694.00	1,506.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,346,300.00	19,346,300.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,346,300.00	19,346,300.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,346,300.00	19,346,300.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,312,555,200.00	1,203,511,118.00	109,044,082.00	91.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,063,903,500.00	1,063,903,500.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,063,903,500.00	1,063,903,500.00	-	100.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	90,000.00	3,645,000.00	(3,555,000.00)	4,050.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	90,000.00	3,645,000.00	(3,555,000.00)	4,050.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	135,963,300.00	135,962,618.00	682.00	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	135,963,300.00	135,962,618.00	682.00	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	112,598,400.00	-	112,598,400.00	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	112,598,400.00		112,598,400.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		112,598,514.56	(112,598,514.56)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		121,989,656.99	(121,989,656.99)	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэг нь “Хүүхэд бүрийг хөгжүүлэн тэднийг эрүүл монгол хүүхэд болгон өсгөн хүмүүжүүлэхэд хүүхэд бүрийн чадамж онцлогт тулгуурласан хүүхдэд ээлтэй цэцэрлэг болох” эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд цэцэрлэгтээ айдасгүй, амар тайван суралцаж, суралцахуйн хоцрогдолгүйгээр эрүүл, аюулгүй, тэгш хүртээмжтэй орчинд сурч хөгжих боломжийг бүрдүүлэх

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

- Багшийн ажлын гүйцэтгэлд суурилсан тасралтгүй хөгжих олон хувилбарт сургалт үйл ажиллагааг зохион байгуулж менежментийг сайжруулах
- Багш ажилтан бүр ёс зүйн хэм хэмжээ шаардлагыг мөрдөж, төсвийг төлөвлөх үр ашигтай зарцуулахад идэвх санаачилгатай оролцох

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд БЕГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан
Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсвийн төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй, шинээр гарсан хууль тогтоомж, дүрэм, журмын өөрчлөлтийг тусгах шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 98,570.1 мянган төгрөгөөр өссөн дүнтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	112,598.5	121,989.6	9,391.1
Бараа материал	87,061.6	129,881.5	42,819.9
Үндсэн хөрөнгө	1,107,883.7	1,154,242.8	46,359.1
Нийт хөрөнгө	1,307,543.8	1,406,113.9	98,570.1
Өр төлбөр	369.8	222.6	(147.2)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,307,174.0	1,405,891.3	98,717.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,307,543.8	1,406,113.9	98,570.1

Дээрх санхүү байдлын тайлангийн үзүүлэлтээс харахад дараах дансанд өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн данс 121,989.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 7.9¹-д заасны дагуу гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд шилжсэнээр төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүйгээс,
- Бараа материалын дансны үлдэгдэл 129,881.5 мянган төгрөг болж 42,819.9 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн Боловсролын газраас 17,600.0 мянган төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүн, сумын ОНХС-аас 8,186.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй ирсэн бараа материалыг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь голлон нөлөөлсөн,

¹ Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,154,242.8 мянган төгрөг болж 46,359.1 мянган төгрөгөөр өссөн нь БЕГ-аас 55,296.8 мянган төгрөгийн, Сүхбаатар сумын ОНХС-аас 16,000.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгийг хүлээн авч бүртгэсэн, тайлант онд 42,532.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг тооцон бүртгэснээс голлон шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэгийн 2024 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 841,718.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг 3,653.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 845,371.7 мянган төгрөгөөр баталсан боловч тайлант онд төсөвт 7 удаа зохицуулалт хийгдэж, улсын төсвөөс 1,063,903.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 135,963.6 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 90.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 112,598.1 мянган төгрөг зэрэг нийт 1,312,555.2 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу улсын төсвөөс 1,063,903.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 135,962.6 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 3,645.0.0 мянган төгрөг зэрэг нийт 1,203,511.1 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,194,120.0 мянган төгрөг буюу 91.0 хувьтай байгаа нь боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 104,035.2 мянган төгрөг, хүүхдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 8,738.9 төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Улсын төсвөөс санхүүжих				
1	80233-Хүүхэд хамгаалал	1,327.0	1,327.0	0.0	100.0
2	81605-Эрүүл мэндийг дэмжих	2,338.4	2,200.0	138.4	94.1
3	81607-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	126,828.1	118,089.2	8,738.9	93.1
4	81816-Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	4,034.9	3,960.0	74.9	98.1
5	81823-Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	2,645.4	1,150.0	1,495.4	43.5

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	982,185.4	878,150.2	104,035.2	89.4
7	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	57,142.7	53,191.0	3,951.7	93.1
8	83603-Нэмэлт -Дээд шатны төсвөөс хуваариласан	90.0	90.0	0.0	100.0
Дүн		1,176,591.9	1,058,157.4	118,434.5	89.9
Орон нутгийн төсвөөс					
9	8011-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	135,963.3	135,962.6	0.7	100.0
Дүн		135,963.3	135,962.6	0.7	100.0
Нийт дүн		1,312,555.2	1,194,120.0	118,435.2	91.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд хүүхдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна.

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах 2 удаагийн нээлттэй тендер шалгаруулалтад оролцогч ирээгүй тул Алтан тариа фүүдс ХХК, Галил этоос ХХК, Царам мөрөн ХХК, Өгөөж ундром дэлгэрэх, Арван агро сэлэнгэ хоршоо, иргэн Ц.Оюун-Эрдэнэ, Д.Цэцэгмаа нартай тус тус шууд гэрээ байгуулан, худалдан авалтыг хийж гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал,

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "Ари файнэнс аудит" ХХК-ийн аудитор Б.Туяа гүйцэтгэж, захирал Д.Ариунаа анхан шатны чанарын хяналтыг, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Ари файнэнс аудит" ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 960,125.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 14,401.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй уялдуулан албан хэрэг эрхлэх ажлыг цахимаар гүйцэтгэж байгаатай холбогдон бичиг хэргийн зардлыг хэмнэсэн, хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд тус цэцэрлэг нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан
Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлээгүй алдаа зөрчлийг давтан гаргасанд албан шаардлага өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	369.8	2	369.8	100.0
Зөвлөмж	3		3		100.0
Нийт дүн	5	369.8	5	369.8	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 17,037.0 мянган төгрөгийн зөрчил илэрч давтан гаргахгүй ажиллах 1 зөвлөмж өгсөн.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн 17,037.0 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.5-д “бүх орлого” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан
Өгсөн зөвлөмж: Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг бүртгэлд бүрэн тусгаж, зарцуулалтад хяналт тавьж ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Эцэг эхчүүдээс авсан хичээлийн болон ариун цэврийн хэрэглэгдэхүүнийг санхүүгийн тайланд тусгаагүй.	1	17,037.0					1	17,037.0				
Дүн	1	17,037.0					1	17,037.0				

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.